



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Эрүүл  
мэндийн төвийн данс бүртгэлээс тээврийн  
хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 21,780,000.0 /хорин нэгэн сая долоон зуун наян мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Мицибуши Делика маркийн 67-88 УНЛ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв (Б.Галсанцэдэн)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв (Б.Галсанцэдэн)-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (А.Мөнгөн)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Б.Болор-Эрдэнэд тус тус даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000193

Тушаал-2021